

ЗАХИРАЛ Ж.БОЛОРМАА

5 ДУГААР СУРГУУЛИЙН **“ГАЗАРЗҮЙ”** ХИЧЭЭЛИЙН 10-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР


ГАЗАР ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН 10-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

1-Р ХЭСЭГ

Мэдлэг ойлголт :

1. Гео-мэдээллийн санд улсын хил, аймгийн хил, нийслэл, аймгийн төв, сумын төв, суурин газруудыг холбосон авто зам, төмөр замыг харуулсан давхаргуудыг сонговол аль төрлийн газар зүйн зураг үүсэх вэ? \1оноо\
А.Байгалийн бүс, бүслүүрийн зураг
В.Хөрсний зураг
С.Замын сүлжээний зураг
D.Тусгай хамгаалалттай газар нутгийн зураг
2. Дараах гаригуудаас хамгийн урт хугацаанд нарыг нэг бүтэн тойрдог гаригийг сонгоно уу? \1оноо\
А.Буд В.Тэнгэрийн ван С.Далай ван D.Дэлхий ван
3. Дараах хотуудын аль хотод нь хамгийн сүүлд нар мандах вэ? \1оноо\
А. Сидней В. Сан Франциско С. Сөүл D. Станбул
4. Дэлхийн хүн амын нягтшил ихтэй Мигинго арал нь аль нуурт оршдог вэ? Зөв хариултыг сонгоорой. \1оноо\
А. Байгаль В. Их баавгайт С. Виктори D. Титикака
5. Астеносфер аль давхаргад байдаг вэ? \1оноо\
А.Газрын давхаргад В.Дээд мантид С.Гадаад цөмд D.Дотоод цөм
6. Газрын давхаргаас доош 2900км зузаан, нягт ихтэй. Энэ давхаргад чичирхийллийн долгионы хурд 8-14км/сек хүрнэ. Физик шинжээр нь дээд ба доод гэж ангилна. Энэ ямар давхарга вэ? \1оноо\
А. Астеносфер В. Газрын давхарга С. Цөм D. Манти
7. Хоёрын тоогоор дэлхийн дотоод бүтцийн ямар хэсгийг тэмдэглэснийг сонгоно уу? \1оноо\
А. Астеносфер В. Газрын давхарга С. Цөм D. Манти

- A.Газрын давхарга
- B.Манти
- C.Гадаад цөм
- D.Дотоод цөм



8. Хийн мандлын үе давхаргуудаас давхраат мандал гэж нэрлэгддэг үеийг сонгоно уу? \1оноо\

- A.Тропосфер
- B.Стратосфер
- C.Мезосфер
- D.Ионсфер

9. Дэлхийн хийн мандлын 5 үеийг ялгахдаа юунд үндэслэдэг вэ? \1оноо\

- A.Салхины хурд
- B.Озоны үетэй
- C.Тунадас унадаг
- D.Температурын өөрчлөлт

10. Нарнаас ирэх цацраг нь энергийн гол эх үүсвэр, дулааны горимыг тогтоогч болдог. Та дараах газруудаар аялах бол ойсон гэрлээс таныг хамгаалах зориулалттай "Нүдний хар шил"-ээ хаана хамгийн их зүүх шаардлагатай вэ? \1оноо\

- A.Ой мод
- B.Хээр тал
- C.Элс
- D.Мөс

11. Байгаль дахь усны эргэлтэнд нөлөөлөх 2 гол хүчин зүйлийг олоорой. \1оноо\

- A. агаарын орчил урсгал, салхи
- B. дэлхийн дотоод энерги, татах хүч
- C. Нарны эрчим хүч, хүндийн хүч
- D. кориолисийн хүч, татах хүч


12.Өндөр ууланд босоо бүслүүр үүсэхэд хамааралгүйг нь сонгоно уу? \1оноо\

- A.Агаарын температурын өөрчлөлт
- B.Агаарын даралтын өөрчлөлт
- C.Агаарын чийгийн өөрчлөлт
- D.Зам тээврийн өөрчлөлт

Чадвар:

13. Зурагт 2019.04.10 өдрийн Монгол орны цасан бүрхүүлийг харуулжээ. Зургийг ажиглан хаагуур цасан бүрхүүл их тогтсоныг сонгоно уу?

\2оноо\



- A.Дорнод
- B.Сүхбаатар
- C.Хөвсгөл
- D.Дундговь

14.Зургийн уртрагийг ажиглан ямар тусгагаар зурсан болохыг сонгоно уу? \2оноо \



- A.Меркаторын
- B.Ламбертийн
- C.Синусоидын
- D.Гүүдийн

15. Дэлхий нарыг 365 хоногт бүтэн 1 тойрч нийт 940 сая км замыг туулдаг. Дэлхий 1 цагт хэдэн км замыг туулдаг вэ? Тооцоолж зөв хариултыг сонгоно уу? \2 оноо\

- A. 107.000 км B. 1.070.000 км C. 2.575.000 км D. 1.790 км

16. Сар нь С үсэг шиг нумарсан хэлбэртэй харагдах нь хэдийд тохиох вэ? \2 оноо \

- A. Эхэн үед тохионо B. Сүүл үеийг илтгэнэ. C.

Дунд үед тохионо.

D. Битүүн үеийг илтгэнэ.


17. Ангараг гариг дэлхийг бодвол хүйтэн байдагийн учир аль нь вэ? \2 оноо\

- A. Агаар мандал байхгүй B. Нарнаас хол оршдог
C. Хэмжээ нь дэлхийгээс бага D. Гадарга нь улаан өнгөтэй

18. БНСУ нь 51 сая хүн амтай, 100 мянган км² талбайтай бол хүн амын нягтшил нь хэд вэ? \2оноо\

- A. 1км² – 5,1 хүн B. 1км² – 51 хүн C. 1км² – 510 хүн D. 1км² – 5100 хүн

19. Хуурай газрын өндөр ба далайн гүн хотгорын дэлхийн гадаргад эзлэх талбайг зурагт илэрхийлжээ. Хуурай газрын хэдэн м өндөртэй гадарга их талбайг эзэлж байна вэ? \2оноо\



- A. 6 км өндөртэй гадарга
B. 1000 м /1км/ хүртэл өндөртэй гадарга
C. 2 км-ын өндөртэй гадарга
D. 5 км гүнтэй далайн хэсэг

20. Мантид хүрэхэд хамгийн ойр байх газрыг сонгоорой. \2оноо\


- A. Гималайн нурууны орой B. Антарктидийн цасан бүрхэвч
C. Марианы хонхор D. Сенесэн тэнгис

21. Өгөгдсөн чулууны зургийг ашиглан, ямар гарал үүсэлтэй болохыг ол. \2оноо\



- A. Хувирмал B. Тунамал
C. Хүрмэн D. Магмын

22. Зургийг ажиглан чулуун мандлын хамрах хүрээг сонгоно уу? \2оноо\




A. Астеносфер хүртэлх дээд мантийн дээд хэсэг, газрын давхаргыг нийлүүлсэн үе давхарга

B. Эх газрын давхаргаас астеносфер хүртэлх 700км гүнтэй үе давхарга

C. Эх газар ба далайн давхаргын 100км гүнтэй үе давхарга

D. Астеносферээс дээд мантийн дээд хэсэг, газрын давхарга хүртэлх үе давхарга

23. Зурагт хөх өнгөөр, агаарын их даралтын мужийг дүрсэлжээ. Монгол оронд их даралтын муж 1030 гПа тогтож байгаа үед ямар улирал болж байх вэ? \1оноо\




A. Зун

B. Намар

C. Өвөл

D. Хавар

24. Антарктид орчим (60°) шөнийн турш нар жаргахгүй тэнгэрийн хаяагаар үзэгдэж байх энэ үед Хойд туйлд (90°) үдийн нарны өндөр хэд байх вэ? \1оноо\




A. 0 градус

B. 30 градус

C. 71 градус

D. 90 градус

25. Зургийг ажиглан үдийн нарны тусгалын өнцөг хэддүгээр өргөрөгт эгц тусч, хаана ямар улирал болж байгааг дүгнэн тодорхойлно уу. \1оноо\




- A. Экватор дээр эгц тусч, хавар намар болж байна
- B. Өмнөд туйл дээр эгц тусч, хойд хагаст өвөл болж байна
- C. Матрын зам дээр эгц тусч, өмнөд хагаст зун болж байна
- D. Мэлхийн зам дээр эгц тусч, хойд хагаст зун болж байна

26. Цаг агаарын мэдээгээр агаарын температур +20C өдөртөө бороотой. Оройдоо даралт нэмэгдэнэ гэсэн бол тухайн өдрийн оройны цаг агаарын төлөв байдал ямар байх вэ? \1оноо\


- A. Үргэлжилсэн бороотой
- B. Бороогүй тэнгэр цэлмэг тогтуун
- C. Шиrүүн усархаг бороотой
- D. Салхитай үүлэрхэг

27. Зурагт даралтын хуваарилалт, тогтмол салхины тухай мэдээлэл өгөджээ. А цэгт үүсэх агаарын хөдөлгөөн, даралтыг тодорхойлоорой. \1 оноо\



- A. А цэгт агаар уруудах хөдөлгөөнтэй , их даралттай
- B. А цэгт агаар өгсөх хөдөлгөөнтэй , их даралттай
- C. А цэгт агаар уруудах хөдөлгөөнтэй , бага даралттай
- D. А цэгт агаар өгсөх хөдөлгөөнтэй , бага даралттай

28. Далайн усны даралт гүн рүүгээ хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлоорой. \2оноо\



.....

29. Дараах байгалийн төрх нь уур амьсгалын ямар нөхцөлд бий болох вэ? \2оноо\



- A. Тропикийн чийглэг уур амьсгал
- B. Газар дундын тэнгисийн уур амьсгал
- C. Тундрын хүйтэн уур амьсгал
- D. Хуурай уур амьсгал

30. Манай орны ой ойн бүлгэмдлийн аль төрөлд хамаарах вэ? \2оноо\

- A. Трипикийн чийглэг ой
- B. Тропикийн ой
- C.

ГДТ-ийн мөнх ногоон ой D. Сэрүүн бүсийн навчит ой ба тайга

Хэрэглээ:

31. 900 км урттай гол 1:1.500.000 масштабтай газрын зураг дээр хэдэн см хэмжээтэй зурагдах вэ? Тооцоолж зөв хариултыг сонгоно уу? \1оноо\

- A. 6 см
- B. 600 см
- C. 60 см
- D. 0.6 см


32. Хүн амын шилжих хөдөлгөөнд “хотоос хөдөө рүү” шилжих хөдөлгөөний татах хүчин зүйлийг сонгоорой. \2оноо\

- A. Дуу чимээний бохирдол бага
- B. Дэд бүтцийн хөгжил сул
- C. Худалдаа үйлчилгээ дутмаг
- D. Их дээд сургуулиуд их

33. Зургийг ажиглан галт уулын тархалт ба тектоникийн хавтангийн хил заагийн хамаарлыг тодорхойлж бичээрэй \2 оноо\

34. Гадаргыг өөрчлөх дараах үйл явцуудаас эндоген үйл явцыг сонгоно уу? \1оноо\

- A. Мөстлөг
- B. Газар хөдлөлт
- C. Цөлжилт
- D. Уул уурхай



.....
.....
.....
.....
.....

35. Агаарын температур ба чийгийн багтаамжийг зурагт үзүүлжээ. Хамаарлыг тодорхойлоорой. \2оноо\



36. Зургийг ажиглан аль үүлнээс хур тунадас орохыг тодорхойлно уу (2оноо)



a. Сэмжин давхраат



b. Борооны давхраат



c. Бөөн



d. Өндрийн бөөн

- A. Сэмжин давхраат
- B. Борооны давхраат
- C. Бөөн
- D. Өндрийн бөөн

37. Далайн эргийн дагуух сөнөсөн бүс аль далайн эргээр хамгийн бага байх вэ?


(2оноо)

- A. Номхон далайн эргээр
- B. Атлантын далайн эргээр
- C. Энэтхэгийн далайн эргээр
- D. Өмнөдийн далайн эргээр

2-Р ХЭСЭГ :

Чадвар:

38. Дараах зураг нь газар хөдлөлтийн идэвхийг 0-4 зэргээр илэрхийлжээ. Манай орны аль хэсэг идэвхтэй болон идэвх багатай бүсэд хамрагдаж байгааг зургаас тодорхойлж бичнэ үү (3 оноо)



39. Газарзүйн зураг дээр тоогоор тектоникийн хавтангуудыг тэмдэглэжээ. Зургийг ажиглаж дараах даалгаврыг гүйцэтгээрэй (4 оноо)



а. 1, 2, 3, 5 тоогоор тэмдэглэсэн тектоникийн хавтангийн нэрийг бичээрэй. \2 оноо\.....

б. Хавтангууд дундаас хамгийн том хавтанг нэрлээрэй \2оноо\

40. Дараах голын уналыг тооцоолоорой. Орхон гол 3021м өндрөөс эх авч 601м өндөрт цутгадаг бол голын унал хэд болохыг тооцоолоорой \3 оноо\

Боловсруулсан : Газар зүйн багш Д. Октябрь